



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2020 оны 04 сарын 21 өдөр

Дугаар 134

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө балансаас балансад
шилжүүлэх тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 31 дүгээр зүйлийн 1, 2, 3 дахь хэсэг, Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 168 дугаар тогтоол, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор батлагдсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 5.1, 5.2 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Соёлын өвийн үндэсний төвийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй хавсралтад заасан 85,000,000.00 (наян таван сая) төгрөгийн балансын үнэ, 76,736,111.40 (далан зургаан сая долоон зуун гучин зургаан мянга нэг зуун арван нэгэн мянга дөчин мөнгө) төгрөгийн хуримтлагдсан элэгдэл бүхий автобусыг Олон улсын хүүхдийн Найрамдал цогцолборт балансаас балансад шилжүүлсүгэй.

2. Соёлын өвийн үндэсний төвийн захирал Г.Энхбат, Олон улсын хүүхдийн Найрамдал цогцолборын ерөнхий захирал Ш.Одончимэг нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Хөрөнгө хүлээлцэх ажлыг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу байгууллагынхаа өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

2.2. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.3. Автомашины улсын дугаарыг шилжүүлсэн тодорхойлолт, арга хэмжээний биелэлтийг 2020 оны 2 дугаар улиралд багтаан ирүүлэх.


3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэлийн хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛИЙН
ХЭЛТСИЙН ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

З.МЭНДСАЙХАН

Д.НАРАНГЭРЭЛ



000124

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
 2020 оны 01 дугаар сарын 01 өдрийн
 13/ дугаар тогтоолын хавсралт

СОЁЛЫН ӨВИЙН ҮНДЭСНИЙ ТӨВИЙН ҮНДСЭН ХӨРӨНГӨД БҮРТГЭЛТЭЙ
 ОЛОН УЛСЫН ХҮҮХДИЙН НАЙРАМДАЛ ЦОГЦОЛБОРТ БАЛАНСААС БАЛАНСАД
 ШИЛЖҮҮЛЭХ ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ

Д/д	Хөрөнгийн нэр	Ашиглалтад орсон огноо	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Балансын үнэ (төгрөг)	Хуримтлагдсан элэгдэл (төгрөг)	Үлдэгдэл өртөг (төгрөг)
1	Паз маркийн 8145 УНХ арал XIM3205EGE0001854	2014	ш	1	85,000,000.00	76,736,111.40	8,263,888.60
	НИЙТ ДҮН			1	85,000,000.00	76,736,111.40	8,263,888.60
					(наян таван сая)	(далан зургаан сая долоон зуун гучин зургаан мянга нэг зуун арван нэгэн мянга дөчин мөнгө)	(найман сая хоёр зуун жаран гурван мянга найман зуун наян найман төгрөг жаран мөнгө)